



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2018 оны 01 сарын 03 өдөр


Дугаар 1/01.

Мөрөн

Журам батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ын “а” заалт, Хог хаягдын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3.12 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хог хаягдлын олон нийтийн байцаагч ажиллуулах, мөнгөн урамшуулалт олгох журмыг хавсралтаар баталсугай.
2. Журмыг хэрэгжүүлж ажиллахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.
3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Х.Ган-Очир)-д даалгасугай.



Аймгийн Засаг даргын 2018-жны 01 дүгээр  
сарын 03-ны өдрийн А/01 дүгээр  
захирамжийн хавсралт

**ХОГ ХАЯГДЛЫН ОЛОН НИЙТИЙН БАЙЦААГЧ АЖИЛЛУУЛАХ,  
МӨНГӨН УРАМШУУЛАЛ ОЛГОХ ЖУРАМ**

БУДАСОТ 2070354

**Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1 “Хог хаягдлын тухай” хуулийн хэрэгжилтэнд хяналт тавих, зохион байгуулах, хог хаягдлын хуулийг сурталчилах хог хаягдлын олон нийтийн байцаагч /цаашид “олон нийтийн байцаагч” гэх/ ажиллуулах, урамшуулал олгох, үйл ажиллагаанд хяналт тавихтай холбогдсон харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2 Журмын зорилго нь сумын иргэдийн эрүүл, аюулгүй орчинд ажиллаж, амьдрах таатай нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор сумын нутаг дэвсгэрт хог хаягдлын олон нийтийн байцаагч ажиллуулж хог хаягдлын чиглэлээр гарсан хууль, тогтоомжийг сурталчлах, биелэлтийг хангуулах, хяналт тавих, зөрчил дутагдлыг арилгуулахад оршино.

1.3 Олон нийтийн байцаагч нь сумын Засаг Даргын Тамгын Газарт харьяалагдах ба сумын Засаг даргаас олгосон албаны үнэмлэхтэй байна.

1.4 Олон нийтийн байцаагч нь үйл ажиллагаандаа Хог хаягдлын тухай, Эрүүл ахуйн тухай хууль тогтоомж, тэдгээртэй нийцүүлэн гаргасан эрх бүхий байгууллагын болон Аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, бүх шатны Засаг даргын шийдвэр болон энэхүү журмыг дагаж мөрдөнө.

**Хоёр. Олон нийтийн байцаагчид тавигдах шаардлага**

2.1. Монгол Улсын иргэн, 18-аас дээш хөдөлмөрийн насны, иргэний эрх зүйн чадамжтай бүрэн дундаас дээш боловсролтой.

2.2. Иргэдийн итгэл хүлээсэн, харилцааны соёлтой, хууль сурталчлах зохион байгуулах, багаар ажиллах, шаардлага тавих чадвартай байх

2.3. Сумын байнгын оршин суугч байх

2.4. Гэмт хэрэгт холбогдож байгаагүй

**Гурав. Олон нийтийн байцаагчийг томилох, чөлөөлөх, ажиллах нөхцөлөөр хангах.**

3.1. Уг журмын 2 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан олон нийтийн байцаагчийг сумын Засаг дарга томилно.

3.2. Томилоход доорх бичиг баримтыг бүрдүүлж, сумын Засаг даргын тамгын газарт ирүүлнэ. Үүнд:

3.2.1. Анкет

3.2.2. Олон нийтийн байцаагчаар ажиллах тухай хүсэлт

3.2.3. Иргэний үнэмлэхний хуулбар

3.2.4. Боловсролын үнэмлэх, дипломын хуулбар

3.2.5. Байгаль орчны хяналтын улсын байцаагчийн санал

3.2.6. Гэмт хэрэгт холбогдож байгаагүй тухай тодорхойлолт

### 3.2.7. 3\*4 хэмжээтэй цээж зураг 2 ширхэг

3.3. Сумын Засаг даргын Тамгын газарт ирүүлсэн материалыг үндэслэн сумын Засаг даргын захирамжаар Хог хаягдлын олон нийтийн байцаагчийг томилж, чөлөөлнө.

3.4. Сумын Засаг даргын захирамжийг үндэслэн Тамгын газрын дарга Олон нийтийн байцаагчтай жил бүр гэрээ байгуулах ба гэрээнд хариуцах ажил, талуудын харилцан хүлээх үүрэг, урамшуулал, гэрээ цуцлах үндэслэлийг заана.

3.5. Олон нийтийн байцаагч нь ажлын төлөвлөгөөг сумын Засаг даргын тамгын газрын даргаар батлуулан хэрэгжүүлж ажиллана.

3.6. Олон нийтийн байцаагчийн гэрээг ажлын үр дүн, зөрчил илрүүлж, зөрчлийг арилгуулахаар авсан арга хэмжээг харгалзан жил бүр сунгана.

3.7. Олон нийтийн байцаагч нь сумын ЗДТГ-ын орон тооны бус, гэрээт ажилтан байна.

3.8. Сумын Засаг даргын тамгын газар хог хаягдлын олон нийтийн байцаагчийг ажиллах өрөө тасалгаа, техник хэрэгсэл, нормын хувцас, хэрэгслээр хангана.

### **3.8. Хог хаягдлын олон нийтийн байцаагчийг чөлөөлөх**

Хог хаягдлын олон нийтийн байцаагчийг дараах тохиолдолд гэрээг цуцалж, чөлөөлнө.

3.8.1. Гэрээнд заасан эрх, үүргээ хэрэгжүүлээгүй, албан тушаалаар хүлээсэн эрхээ хэтрүүлэн ашигласан нь нотлох баримтаар тогтоогдсон бол

3.8.2. Өөр ажил, албан тушаалд томилогдох болсон

3.8.3. Гэмт хэрэг үйлдсэн нь эрх бүхий байгууллагаар тогтоогдсон бол

3.8.4. Эрүүл мэндийн болон бусад шалтгаанаар өөрөө хүсэлтээ гаргасан бол

### **Дөрөв. Хог хаягдлын олон нийтийн байцаагч дараах үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажиллана.**

4.1.1. Олон нийтийн байцаагч нь Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Хог хаягдлын тухай хууль, Орчны эрүүл ахуйн тухай хууль, Агаарын тухай хууль, түүнтэй нийцүүлэн гаргасан эрх бүхий байгууллага, аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, бүх шатны Засаг даргын шийдвэрийг сурталчилах, хэрэгжүүлэхээс гадна дараах чиглэлийн үйл ажиллагаанд хяналт тавина.

4.1.2. Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайн тохижилт, цэвэрлэгээ нийтийн эзэмшлийн тавилга, эд хөрөнгийн арчлалт, хамгаалалт, үерийн хамгаалалтын далан суваг, барилга байгууламжийн засвар, цэвэрлэгээ үйлчилгээнд хяналт тавих, орон сууцны болон гэр хорооллын гудамж, зам талбайд ил задгай хог хаягдал үүсэхээс урьдчилан сэргийлэх, гарсан зөрчлийг арилгуулах арга хэмжээ авч ажиллана.

4.1.3. Хариуцсан нутаг дэвсгэрийн байнга болон түр оршин суугч айл өрх, аж ахуйн нэгж байгууллагатай хог хаягдлын үйлчилгээний гэрээ байгуулж, хог хаягдлын үйлчилгээний хураамжийн орлого төвлөрүүлэлт болон гэрээний биелэлтэд хяналт тавина.

4.1.4. Хот, нийтийн эд аж ахуй, байгаль экологи, хүрээлэн буй орчинд сөргөөр нөлөөлөх үйлдлийг таслан зогсоож, холбогдох хууль тогтоомжоор олгогдсон эрхийн хүрээнд илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах арга хэмжээ авч эрх бүхий албан тушаалтанд мэдэгдэнэ.

4.1.5. Хариуцсан нутаг дэвсгэрийн аж ахуйн нэгж, байгууллагын хариуцах ойр орчны 50м хүртэлх нийтийн эдэлбэр газар, авто машины болон явган хүний замын хог хаягдал, цас, мөсийг цэвэрлүүлэх, тохижилтыг хийлгэх ажлыг зохион байгуулах, хяналт тавих, аж ахуйн нэгж байгууллагын идэвх санаачилгыг өрнүүлэх.

4.1.8. Бүх нийтийг хамарсан ажилд хариуцсан нутаг дэвсгэрийн иргэд, байгууллага, аж ахуйн нэгжийг бүрэн хамруулах, зар түгээх, сурталчлах.

4.1.10 Хог хаягдлын талаархи олон нийтийн боловсролыг дээшлүүлэх ажилд холбогдох төрийн болон төрийн бус байгууллага, багийн Засаг даргатай хамтран ажиллана.

4.1.11. Хог хаягдлыг бууруулах, эдийн засгийн эргэлтэд оруулах санал санаачилга гаргах, зохион байгуулах үүрэг бүхий орон тооны бус иргэдийн бүлэг байгуулж ажиллуулахад багийн Засаг даргатай хамтарч ажиллана.

4.1.12. Хариуцсан багийн нутаг дэвсгэрийг хог хаягдалгүй, орчны бохирдолгүй байлгахад чиглэсэн шинэлэг санал санаачлага гаргаж, хэрэгжүүлэх.

4.1.13. Тухайн нутаг дэвсгэрт тогтоосон агаарын чанарыг сайжруулах хязгаарлалтын бүсийн журам, дүрмийг хэрэгжүүлэхэд хяналт тавих

4.1.14. Удаа, дараа зөрчил гаргасан, тавьсан шаардлагыг биелүүлээгүй иргэн, аж ахуйн нэгж байгууллагад хууль тогтоомжид заасан хариуцлагыг тооцуулах, цуцлуулах саналыг холбогдох эрх бүхий этгээдэд тавьж, шийдвэрлүүлэх.

### **Тав. Зөрчил хянах**

5.1. Хог хаягдлын олон нийтийн байцаагч нь хяналт тавих чиг үүргээ хэрэгжүүлэхдээ илэрсэн зөрчлийн талаар эрх бүхий улсын байцаагчид нэн даруй танилцуулж холбогдох арга хэмжээг авахуулна.

### **Зургаа. Тайлан хүргүүлэх.**

7.1. Олон нийтийн байцаагч нь ажлын тайланг сар, хагас жил, бүтэн жилээр гаргаж сумын Засаг даргын тамгын газарт өгнө.

7.2. Илрүүлсэн зөрчил, дутагдлын дагуу авсан арга хэмжээний мэдээг сумын Засаг даргад сар бүрийн 05-ны өдрийн дотор хүргүүлнэ.

### **Долоо. Мөнгөн урамшуулалт олгох**

7.1. Хог хаягдлын олон нийтийн байцаагчийн урамшууллыг Төрийн үйлчилгээний албан хаагчийн цалингийн шатлалтай жишиж тооцож олгоно.

7.2. Сумын Засаг дарга олон нийтийн байцаагчийн мөнгөн урамшууллын зардлыг жил бүр орон нутгийн төсөвт тусгаж, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулж, хэрэгжүүлнэ.

7.3. Олон нийтийн байцаагчийн ажлын үр дүнгээс хамааруулан жилд 1 удаа мөнгөн шагнал олгож болно.



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2018 оны 01 сарын 08 өдөр


Дугаар 102

Мөрөн

Гадаад албан томилолт олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, Засгийн газрын 2013 оны 320 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

- Хөвсгөл аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга Нямдоржийн Бямбадорж нь Бүгд Найрамдах Солонгос Улсад 2018 оны 1 дүгээр сарын 24-28-ны өдрүүдэд зохион байгуулагдах “Барилгын талбайн аюулгүй ажиллагаа” сэдэвт сургалтад оролцох тул гадаад албан томилолт олгосугай.
- Нямдоржийн Бямбадоржийн албан паспорт шинээр авахтай холбоотой материалыг бүрдүүлж, Гадаад харилцааны яаманд хүргүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга (Х.Цэнд-Аюуш)-д даалгасугай.
- Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Х.Ган-Очир)-д даалгасугай.





МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2018 оны 01 сарын 08 өдөр

Дугаар A/03

Мөрөн

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5-ын "а", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийн 47.1 дэх заалтууд, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2013 оны 43 дугаар тогтоол, Сангийн Сайдын 2014 оны 212 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Хот тохижуулах үйлчилгээний төвийн даргын 2018 оны 03, 04 дүгээр албан бичгээр ирүүлсэн хүсэлтийн дагуу тус төвд өөрийн хөрөнгөөр 106,737,800 (Зуун зургаан сая долоон зуун гучин долоон мянга найман зуун) төгрөгийн төсөвт өртөг бүхий шатах тослох материал нийлүүлэх гүйцэтгэгч сонгох үнэлгээний хороог нэгдүгээр, 37,986,000 (Гучин долоон сая есөн зуун наян зургаан мянган) төгрөгийн төсөвт өртөг бүхий урсгал засварын материал нийлүүлэх гүйцэтгэгч сонгох үнэлгээний хороог хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Худалдан авах ажиллагааг хууль, журам, батлагдсан төлөвлөгөөний дагуу зохион байгуулахыг үнэлгээний хорооны дарга (Э.Аззаяа)-д даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Хот тохижуулах үйлчилгээний төвийн дарга (Ч.Батсүх)-д үүрэг болгосугай.



Аймгийн Засаг даргин 2018 оны 01 дүгээр  
сарын 8-ны өдрийн А/О дүгээр  
захирамжийн 01 дүгээр хавсралт


РЮА0007 9070354

АЙМГИЙН ХОТ ТОХИЖУУЛАХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВД ШАТАХ  
ТОСЛОХ МАТЕРИАЛ НИЙЛҮҮЛЭХ ГҮЙЦЭТГЭГЧ СОНГОХ  
СОНГОХ ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН  
(Төсөвт өртөг-106,737,800 төгрөг)

Үнэлгээний хорооны дарга: Э.Аззаяа-Аймгийн Засаг даргын Тамгын газрын  
Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн даргын үүргийг  
түр орлон гүйцэтгэгч

Гишүүд: В.Олдох-Аймгийн Хүнсчдийн холбооны тэргүүн  
Б.Сүнжидмөнх-Мөрөн сумын Засаг даргын Тамгын газрын мэргэжилтэн  
О.Алтантариа-Аймгийн Хот тохижуулах үйлчилгээний төвийн бичиг хэргийн  
ажилтан

Нарийн бичгийн дарга: Н.Шинэбаяр-Аймгийн Орон нутгийн өмчийн газрын  
Өмчийн хэлтсийн дарга



**АЙМГИЙН ХОТ ТОХИЖУУЛАХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВД УРСГАЛ  
ЗАСВАРЫН МАТЕРИАЛ НИЙЛҮҮЛЭХ ГҮЙЦЭТГЭГЧ  
СОНГОХ ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН  
(Төсөвт өртөг-37,986,000 төгрөг)**

Үнэлгээний хорооны дарга: Э.Аззаяа-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч

Гишүүд: В.Олдох-Аймгийн Хүнсчдийн холбооны тэргүүн  
Б.Сүнжидмөнх-Мөрөн сумын Засаг даргын Тамгын газрын мэргэжилтэн  
О.Алтанариа-Аймгийн Хот тохижуулах үйлчилгээний төвийн бичиг хэргийн ажилтан

Нарийн бичгийн дарга: Н.Шинэбаяр-Аймгийн Орон нутгийн өмчийн газрын Өмчийн хэлтсийн дарга



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2018 оны 01 сарын 08 өдөр

Дугаар А/ОЧ

Мөрөн

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5-ын "а", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийн 47.1 дэх заалтууд, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2013 оны 43 дугаар тогтоол, Сангийн Сайдын 2014 оны 212 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын даргын 2018 оны 01 дүгээр албан бичгээр ирүүлсэн хүсэлтийн дагуу улсын төсвийн урсгал зардлаас санхүүжих "Нийгмийн хамгааллын дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхөд 2,074,000,000 (Хоёр тэрбум далан дөрвөн сая) төгрөгийн төсөвт өртөг бүхий хүнсний эрхийн бичгээр олгох дэлгүүр, аж ахуйн нэгж сонгох үнэлгээний хороог нэгдүгээр, ахмадын сувилалд 77,962,500 (Далан долоон сая есөн зуун жаран хоёр мянга таван зуун) төгрөгийн төсөвт өртөг бүхий хоол, хүнсний материал нийлүүлэх гүйцэтгэгч сонгох үнэлгээний хороог хоёрдугаар, 12,699,100 (Арван хоёр сая зургаан зуун ерэн есөн мянга нэг зуун) төгрөгийн төсөвт өртөгтэй шатах тослох материал нийлүүлэх гүйцэтгэгч сонгох үнэлгээний хороог гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Худалдан авах ажиллагааг хууль, журам, батлагдсан төлөвлөгөөний дагуу зохион байгуулахыг үнэлгээний хорооны дарга (З.Огтонбаяр)-д даалгасугай.


3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын дарга (Б.Эрдэнэхуяг)-д үүрэг болгосугай.

ДАРГА

Л.ГАНБОЛД



02 Фото



**"НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ДЭМЖЛЭГ ТУСЛАЛЦАА ЗАЙЛШГҮЙ  
ШААРДЛАГАТАЙ ӨРХӨД ХҮНСНИЙ ЭРХИЙН БИЧГЭЭР  
ҮЙЛЧЛЭХ ДЭЛГҮҮР, АЖ АХУЙН НЭГЖ СОНГОХ  
ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН  
(Төсөвт өртөг-2,074,000,000 төгрөг)**

Үнэлгээний хорооны дарга: З.Отгонбаяр-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн

Гишүүд: Т.Раднаабүд-Аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын захиргаа, хяналтын хэлтсийн дарга

Г.Оюундулам-Мөрөн сумын иргэн

Д.Лхагвадулам-Мөрөн сумын иргэн

Нарийн бичгийн дарга: Ц.Эрдэнэбаатар-Аймгийн Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах ажиллагааны хэлтсийн мэргэжилтэн

Аймгийн Засаг даргын 2018 оны 1 дүгээр  
сарын 8-ны өдрийн А/04 дүгээр  
захирамжийн 02 дугаар хавсралт

РНГДСОБУЛ 9070354

АЙМГИЙН ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ  
ГАЗРЫН ХАРЬЯА АХМАДЫН СУВИЛАЛД ХООЛ,  
ХҮНСНИЙ МАТЕРИАЛ НИЙЛҮҮЛЭХ ГҮЙЦЭТГЭГЧ  
ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН  
(Төсөвт өртөг-77,962,500 төгрөг)

Үнэлгээний хорооны дарга: З.Отгонбаяр-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн


Гишүүд: Т.Раднаабүд-Аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын захиргаа, хяналтын хэлтсийн дарга

Г.Оюундулам-Мөрөн сумын иргэн

Д.Лхагвадулам-Мөрөн сумын иргэн

Нарийн бичгийн дарга: Ц.Эрдэнэбаатар-Аймгийн Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах ажиллагааны хэлтсийн мэргэжилтэн

Аймгийн Засаг даргын 2018 оны 1 дүгээр  
сарын 8-ны өдрийн А/04 дүгээр  
захирамжийн 03 дугаар хавсралт



АЙМГИЙН ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ  
ГАЗАРТ ШАТАХ ТОСЛОХ МАТЕРИАЛ НИЙЛҮҮЛЭХ  
ГҮЙЦЭТГЭГЧ ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН  
(Төсөвт өртөг-12,699,100 төгрөг)

Үнэлгээний хорооны дарга: З.Отгонбаяр-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн

Гишүүд: Т.Раднаабүд-Аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын захиргаа, хяналтын хэлтсийн дарга

Г.Оюундулам-Мөрөн сумын иргэн

Д.Лхагвадулам-Мөрөн сумын иргэн

Нарийн бичгийн дарга: Ц.Эрдэнэбаатар-Аймгийн Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах ажиллагааны хэлтсийн мэргэжилтэн



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2018 оны 01 сарын 08 өдөр

Дугаар A/05

Мөрөн

Үнэлгээний хороо байгуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5-ын “а”, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийн 47.1 дэх заалтууд, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2013 оны 43 дугаар тогтоол, Сангийн Сайдын 2014 оны 212 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Галт сумын ерөнхий боловсролын сургуулийн захирлын 2017 оны 74 дүгээр албан бичгээр ирүүлсэн хүсэлтийн дагуу тус сургуульд улсын төсвийн урсгал зардлын хөрөнгөөр 145,028,300 (Нэг зуун дөчин таван сая хорин найман мянга гурван зуун) төгрөгийн төсөвт өртөг бүхий хоол, хүнсний материал нийлүүлэх гүйцэтгэгч сонгох үнэлгээний хороог нэгдүгээр, 42,157,000 (Дөчин хоёр сая нэг зуун тавин долоон мянган) төгрөгийн төсөвт өртөг бүхий үдийн цай нийлүүлэх гүйцэтгэгч сонгох үнэлгээний хороог хоёрдугаар, 15,000,000 (Арван таван сая) төгрөгийн төсөвт өртөг бүхий түлш, халаалт нийлүүлэх гүйцэтгэгч сонгох үнэлгээний хороог гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Худалдан авах ажиллагааг хууль, журам, батлагдсан төлөвлөгөөний дагуу зохион байгуулахыг үнэлгээний хорооны дарга (Б.Болд)-д даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Галт сумын ерөнхий боловсролын сургуулийн захирал (А.Цэрэнхүү)-д үүрэг болгосугай.

ДАРГА  Л.ГАНБОЛД



ГАЛТ СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД  
ХООЛ, ХҮНСНИЙ МАТЕРИАЛ НИЙЛҮҮЛЭХ ГҮЙЦЭТГЭГЧ  
СОНГОХ ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН  
(Төсөвт өртөг-145,028,300)


Үнэлгээний хорооны дарга: Б.Болд-Аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга

Гишүүд: Ц.Бямбатөр-Аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын мэргэжилтэн

Б.Жавзандулам-Аймгийн Нэгдсэн эмнэлгийн нягтлан бодогч

З.Отгонбаяр-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн

Нарийн бичгийн дарга: А.Цэрэндуулам-Аймгийн Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах ажиллагааны хэлтсийн дарга



Аймгийн Засаг дарын 2018 оны 11 дугаар  
сарын 8-күү өдрийн А/05 дугаар  
захирамжийн 02 дугаар хавсралт

ГАЛТ СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД  
ҮДИЙН ЦАЙ НИЙЛҮҮЛЭХ ГҮЙЦЭТГЭГЧ СОНГОХ  
ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН  
(Төсөвт өртөг-42,157,000)


Үнэлгээний хорооны дарга: Б.Болд-Аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга

Гишүүд: Ц.Бямбатөр-Аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын мэргэжилтэн

Б.Жавзандулам-Аймгийн Нэгдсэн эмнэлгийн нягтлан бодогч

З.Отгонбаяр-Аймгийн Засаг дарын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн

Нарийн бичгийн дарга: А.Цэрэндулам-Аймгийн Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах ажиллагааны хэлтсийн дарга



ГАЛТ СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД  
ТУЛШ, ХАЛААЛТЫН МАТЕРИАЛ НИЙЛҮҮЛЭХ ГҮЙЦЭТГЭГЧ  
СОНГОХ ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ БҮРЭЛДХҮҮН  
(Төсөвт өртөг-15,000,000)

Үнэлгээний хорооны дарга: Б.Болд-Аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга

Гишүүд: Ц.Бямбатөр-Аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын мэргэжилтэн  
Б.Жавзандулам-Аймгийн Нэгдсэн эмнэлгийн нягтлан бодогч  
З.Отгонбаяр-Аймгийн Засаг дарын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн

Нарийн бичгийн дарга: А.Цэрэндуулам-Аймгийн Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах ажиллагааны хэлтсийн дарга



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2018 оны 01 сарын 08 өдөр

Дугаар А/06

Мөрөн

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5-ын “а”, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийн 47.1 дэх заалтууд, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2013 оны 43 дугаар тогтоол, Сангийн Сайдын 2014 оны 212 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мөрөн сумын “Сод Эрдэм” сургуулийн захирлын 2018 оны 01 дүгээр албан бичгээр ирүүлсэн хүсэлтийн дагуу тус сургуульд улсын төсвийн урсгал зардлын хөрөнгөөр 37,451,700 (Гучин долоон сая дөрвөн зуун тавин нэгэн мянга долоон зуун) төгрөгийн төсөөт өртөг бүхий үдийн цай нийлүүлэх гүйцэтгэгч сонгох үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Үнэлгээний хорооны дарга: Б.Болд-Аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга

Гишүүд: В.Олдох-Аймгийн Хүнсчдийн холбооны тэргүүн

Ч.Лхагвасүрэн-“Сайн засаглалыг дэмжигч иргэдийн оролцоо” төрийн бус байгууллагын ажилтан


Г.Оюундулам-“Сод Эрдэм” ахлах сургуулийн номын санч

Нарийн бичгийн дарга: Ц.Бямбажав-Аймгийн Орон нутгийн өмчийн газрын нягтлан бодогч

2. Худалдан авах ажиллагааг хууль, журам, батлагдсан төлөвлөгөөний дагуу зохион байгуулахыг үнэлгээний хорооны дарга (Б.Болд)-д даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Мөрөн сумын “Сод Эрдэм” ахлах сургуулийн захирал (Д.Сэвжидхорлоо)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Л.ГАНБОЛД

00 000000



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2018 оны 01 сарын 08 өдөр

Дугаар А/07

Мөрөн

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5-ын “а”, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийн 47.1 дэх заалтууд, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2013 оны 43 дугаар тогтоол, Сангийн Сайдын 2014 оны 212 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Эрүүл мэндийн газрын даргын 2018 оны 01 дүгээр албан бичгээр ирүүлсэн хүсэлтийн дагуу тус газарт улсын төсвийн урсгал зардлын хөрөнгөөр 16,545,000 (Арван зургаан сая таван зуун дөчин таван мянган) төгрөгийн төсөвт өртөг бүхий шатах тослох материал нийлүүлэх гүйцэтгэгч сонгох үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Үнэлгээний хорооны дарга: Б.Болд-Аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга

Гишүүд: Ч.Лхагвасүрэн-“Сайн засаглалыг дэмжигч иргэдийн оролцоо” төрийн бус байгууллагын ажилтан

Б.Батбаяр-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

О.Эрдэнэбаатар-Мөрөн сумын иргэн


Нарийн бичгийн дарга: Ч.Лхагвамядаг-Аймгийн Орон нутгийн өмчийн газрын Өмчийн хэлтсийн мэргэжилтэн

2. Худалдан авах ажиллагааг хууль, журам, батлагдсан төлөвлөгөөний дагуу зохион байгуулахыг үнэлгээний хорооны дарга (Б.Болд)-д даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Эрүүл мэндийн газрын дарга (М.Үүрийнбаяр)-д үүрэг болгосугай.

ДАРГА

Л.ГАНБОЛД



00 50.9  
d:/zahiramj



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2018 оны 01 сарын 08 өдөр

Дугаар A/08

Мөрөн

Худалдан авах ажиллагааны 2018 оны  
нэгдсэн төлөвлөгөө батлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.4, Төсвийн тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1.1 дэх заалтууд, Сангийн сайдын 2017 оны 363 дугаар тушаал, аймгийн ИТХ-ын хуралдааны 2017 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн ээлжит V хуралдааны 06 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар Хөвсгөл аймагт 2018 онд зохион байгуулах худалдан авах ажиллагааны нэгдсэн төлөвлөгөөг 01-04 дүгээр хавсралтуудаар тус тус баталсугай.

2. Төсөвт болон орон нутгийн өмчийн аж ахуйн нэгж, байгууллагын захирал, дарга нарт ДААЛГАХ нь:

-Төрийн худалдан авах ажиллагааны цахим системийг ашиглан худалдан авах ажиллагааг 100 хувь цахимжуулах зорилгоор 2018 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хойш зарлах бүх тендер шалгаруулалтын төлөвлөгөө, урилгыг төрийн худалдан авах ажиллагааны цахим системд нийтэлж, үр дүнг тухай бүр цахим системд оруулах ба уг шаардлагыг хангаагүй худалдан авах ажиллагаанд санхүүжилт олгохгүй байх,

-Худалдан авах ажиллагааг цахим системээр зарласныг нотлох баримт болох тендерийг цахим системд нийтэлсэн урилга, тендерийн үр дүнгийн мэдээллийг [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) цахим системээс татаж хэвлэсэн хуудас болон холбогдох баримт бичгийг үндэслэн урсгал болон хөрөнгийн зардлаар худалдан авсан төсөл, арга хэмжээний санхүүжилтийг олгох.


-Өөрийн төсвийн багцад хамаарах захиалагч байгууллагуудын худалдан авах ажиллагааны хэрэгжилтэнд хяналт тавьж, үр дүнг тайланд нэгтгэн тусгаж, гарсан зөрчлийг тухай бүр арилгуулах арга хэмжээ авах,

-Гэрээний үүргээ хангалтгүй биелүүлсэн аж ахуйн нэгжийг тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлд бүртгүүлэх тухай саналаа тухай бүр аймгийн Засаг даргад ирүүлэх,

0110032  
d:/zahiramj

-Худалдан авах ажиллагааны тайлангийн үнэлгээгээр хангалтгүй үнэлэгдсэн сүм, агентлагийн удирдлагууд, холбогдох албан тушаалтнуудад хариуцлага тооцох саналаа тухай бүр ирүүлэх.

3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга / Б.Болд /-д үүрэг болгосугай.





МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2018 оны 01 сарын 08 өдөр

Дугаар A/09


Мөрөн

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5-ын "а", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийн 47.1 дэх заалтууд, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2013 оны 43 дугаар тогтоол, Сангийн Сайдын 2014 оны 212 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

- Хатгал тосгоны Эрүүл мэндийн төвийн даргын 2017 оны 26 дугаар албан бичгээр ирүүлсэн хүсэлтийн дагуу тус төвд улсын төсвийн урсгал зардлын хөрөнгөөр 11,425,100 (Арван нэгэн сая дөрвөн зуун хорин таван мянга нэг зуун) төгрөгийн төсөвт өртөг бүхий шатах, тослох материал нийлүүлэх гүйцэтгэгч сонгох үнэлгээний хороог нэгдүгээр, 13,693,700 (Арван гурван сая зургаан зуун ерэн гурван мянга долоон зуун) төгрөгийн төсөвт өртөг бүхий түлш, халаалтын материал нийлүүлэх гүйцэтгэгч сонгох үнэлгээний хороог хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
- Худалдан авах ажиллагааг хууль, журам, батлагдсан төлөвлөгөөний дагуу зохион байгуулахыг үнэлгээний хорооны дарга (Б.Болд)-д даалгасугай.
- Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хатгал тосгоны Эрүүл мэндийн төвийн дарга (П.Цэрэндолгор)-д үүрэг болгосугай.

ДАРГА Л.ГАНБОЛД



ХАТГАЛ ТОСГОНЫ ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВД ШАТАХ,  
ТОСЛОХ МАТЕРИАЛ НИЙЛҮҮЛЭХ ГҮЙЦЭТГЭГЧ  
СОНГОХ ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН  
(Төсөөт өртөг-11,425,100 төгрөг)


Үнэлгээний хорооны дарга: Б.Болд-Аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга

Гишүүд: Ч.Лхагвасурэн-“Сайн засаглалыг дэмжигч иргэдийн оролцоо” төрийн бус  
байгууллагын ажилтан

Ж.Балдандорж-Аймгийн Ногоочдын холбооны тэргүүн

Б.Жавзандулам-Аймгийн Нэгдсэн эмнэлгийн няглан бодогч

Нарийн бичгийн дарга: Ц.Бэхбаяр-Аймгийн Орон нутгийн өмчийн газрын Өмчийн  
хэлтсийн мэргэжилтэн



Аймгийн Засаг дарын 2018 оны 1 дүгээр  
сарын 8-ны өдрийн А/09 дүгээр  
захирамжийн 02 дугаар хавсралт

**ХАТГАЛ ТОСГОНЫ ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВД ТҮЛШ,  
ХАЛААЛТЫН МАТЕРИАЛ НИЙЛҮҮЛЭХ ГҮЙЦЭТГЭГЧ  
СОНГОХ ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН**  
(Төсөвт өртөг-13,693,700 төгрөг)

Үнэлгээний хорооны дарга: Б.Болд-Аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга  
Гишүүд: Ч.Лхагвасүрэн-“Сайн засаглалыг дэмжигч иргэдийн оролцоо” төрийн бус  
байгууллагын ажилтан  
Ж.Балдандрж-Аймгийн Ногоочдын холбооны тэргүүн  
Б.Жавзандулам-Аймгийн Нэгдсэн эмнэлгийн нягтлан бодогч  
Нарийн бичгийн дарга: Ц.Бэхбаяр-Аймгийн Орон нутгийн өмчийн газрын Өмчийн  
хэлтсийн мэргэжилтэн



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2018 оны 01 сарын 11 өдөр


Дугаар 110

Мөрөн

Шагнах тухай

Монгол Улсын Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 4.1.3, 4.1.5, 7.3, Засгийн газрын 1997 оны 54 дүгээр тогтоолыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

- Цагаан сар, Олон улсын эмэгтэйчүүдийн өдрийг тохиолдуулан эрхэлсэн ажилдаа олон жил үр бүтээлтэй ажиллаж, хөдөлмөрийн тогтвортой амжилт гаргаж, аймаг орон нутгийнхаа хөгжил дэвшилд бодитой хувь нэмэр оруулж байгаа хавсралтанд дурьдсан нэр бүхий иргэдийг шагнаж урамшуулсугай.
- Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга /Х.Цэнд-Аюуш/-д даалгасугай.



Аймгийн Засаг даргын 2018 оны  
01 дүгээр сарын 11-ний өдрийн А/10 дугаар  
захирамжийн хавсралт

### Б. Аймгийн Тэргүүний ажилтан

|    |                               |   |
|----|-------------------------------|---|
| 01 | Пүрэвсүрэн Насанбуян          | Рашаант сумын 3ДТГ-ын Архив биний хэргийн эрхлэгч |
| 02 | Жанцан Базаррагчаа            | Мөрөн сумын 12-р багийн өндөр настан              |
| 03 | Пүрэв Дагвадорж               | Мөрөн сумын 11-р багийн өндөр настан              |
| 04 | Базардарь Батхуяг             | Мөрөн сумын 10-р багийн өндөр настан              |
| 05 | Пүрэвжал Батсүх               | Эрдэнэбулган сумын өндөр настан, ахмад тамирчин   |
| 06 | С. Баатар                     | Баянзүрх сумын иргэн                              |
| 07 | Ч.Төмөрбаатар                 | Баянзүрх сумын иргэн                              |
| 08 | Ш.Лхагважий                   | Баянзүрх сумын иргэн                              |
| 09 | Рэгзэн Дашидараа              | Тариалан сумын 2-р багийн малчин                  |
| 10 | Гомбосурэн Алтанхуяг          | Арбулаг сумын 1-р багийн малчин                   |
| 11 | Цэдэн-Иш Тэрбиш               | Тариалан сумын ахмад настан                       |
| 12 | Батжаргал Эрдэнэчuluун        | Тосонцэнгэл сумын хүүхдийн цэцэрлэгийн нярав      |
| 13 | Донгундэв Балзмаа             | Галт сумын Зүрх багийн ахмад настан               |
| 14 | Гомбосурэн Нямдорж            | Хатгал тосгоны ахмад настан                       |
| 15 | Лхамсүрэн Пүрэвдорж           | Шинэ -Идэр сумын 4-р багийн ахмад                 |
| 16 | Эрдэнэбат Долгорсүрэн         | Шинэ -Идэр сумын 3-р багийн ахмад                 |
| 17 | Лувсан Баасан                 | Мөрөн сумын 3-р багийн ахмад настан               |
| 18 | Гүнчгээ Дүүжий                | Ренчинлхумбэ сумын ахмад настан                   |
| 19 | Гүнчгээ Хүүжий                | Ренчинлхумбэ сумын ахмад настан                   |
| 20 | Самдан Бямбасүрэн             | Ренчинлхумбэ сумын ахмад настан                   |
| 21 | Жамсран Лаагансүрэн           | Морин чаргачдын холбооны тэргүүн                  |
| 22 | Лхамжав Цэнд-Аюуш             | Хатгал тосгоны өндөр настан                       |
| 23 | Гэлэгнамжил Загдаа            | Хатгал тосгоны өндөр настан                       |
| 24 | Алтангэрэл Цэнд-Аюуш          | Тариалан сумын ахмад настан                       |
| 25 | Архайд Гантулга               | ХДТ-ын бүжиг ангийн багш                          |
| 26 | Балжинням Баярмаа             | Зэвсэгт хүчний 0321-р ангийн тогооч               |
| 27 | Данаажав Эрдэнэтүүл           | Гоо даль салоны үсчин                             |
| 28 | Алтангэрэл Дарьжав            | Түнэл сумын 5-р багийн малчин                     |
| 29 | Авид Оюунбилэг                | Түнэл сумын 3-р багийн малчин                     |
| 30 | Чойжамц Нямбуу                | Түнэл сумын 1-р багийн малчин                     |
| 31 | Чулуунбат Баасансүрэн         | Хөгжимт драмын театрны дуучин                     |
| 32 | Лхамсүрэн Сүрэнхүү            | Цагаан -Уул сумын Хужирт багийн малчин            |
| 33 | Лувсангончиг Оюунтөгс         | Цагаан -Уул сумын Шарга багийн малчин             |
| 34 | Билэгдэмбэрэл<br>Жаргалсайхан | Төмөрбулаг сумын ЗДТГ-ын Байгаль хамгаалагч       |
| 35 | Бат Оюунцэцэг                 | Цагаан-Уул сумын цаг уурын ажиглагч               |
| 36 | Тэрбиш Амармөрөн              | Бүрэнтогтох сумын ЗДТГ-ын үйлчлэгч                |
| 37 | Лхагвасүрэн Ганзам            | Бүрэнтогтох сумын соёлын төвийн үйлчлэгч, нярав   |
| 38 | Чулуунжав Цэрэндулам          | Алаг-Эрдэнэ сумын 5-р багийн малчин               |
| 39 | Норовсамбуу Дувжир            | Аймгийн УЦУОШГ-ын өртөөний техникик               |
| 40 | Баасанцэрэн Одсүрэн           | Ханх сумын ЕБС-ийн ахмад багш                     |
| 41 | Бат Ганбаатар                 | Алаг-Эрдэнэ сумын ЕБС-ийн технологийн багш        |
| 42 | Найдансүрэн Болормаа          | Шинэ-Идэр сумын ЗДТГ-ын дотоод ажилтан            |
| 43 | Чойжилжав Цэрэнпил            | "Тэс Гүн" ХХК-ийн цехийн ажилтан                  |
| 44 | Дондов Гомбожав               | 321-р тусгай салбарын ахлах оператор              |
| 45 | Ням-Очир Түвшэндорж           | ОБГ-ын гал сенөөгч                                |
| 46 | Доной Бужинлхам               | Хилийн 0257-р ангийн тогооч                       |
| 47 | Эрдэнэбилэг Мөнхчuluун        | ШШГА-ны хянаагч                                   |

|    |                           |   |
|----|---------------------------|---|
| 48 | Шаарий Уранчимэг          | ШША-ны туслах ажилтан                                       |
| 49 | Алтангэрэл Амгаланбаатар  | Тагнуулын хэлтсийн ахлах ажилтан                            |
| 50 | Магсар Цолмонгэрэл        | Хилийн 0257-р ангийн ахлах ахлагч                           |
| 51 | Пэрэнлэйхүндэв Наранцэцэг | Галт сумын ЭМТ-ийн дарга                                    |
| 52 | Должинжав Оюунчимэг       | Нэгдсэн эмнэлгийн тархвар судлаач эмч                       |
| 53 | Чойжилжав Жаргалсайхан    | Цэцэрлэг сумын ЕБС-ийн байрын багш                          |
| 54 | Баттөмөр Батцэцэг         | Шинэ-Идэр сумын ЕБС-ийн үйлчлэгч                            |
| 55 | Жамба Дарамсэнгэ          | ХДТ-ын ахмад найруулагч                                     |
| 56 | Гомбосүрэн Нармандах      | Бүрэнтогтох сумын Их-Уул багийн малчин                      |
| 57 | Дэжид Оюунцэцэг           | Бүрэнтогтох сумын Баянхошуу багийн малчин                   |
| 58 | Бат Уранчимэг             | Цагаан-Уул сумын худалдаа эрхлэгч                           |
| 59 | Лхагва Өлзийтөгс          | Мөрөн сумын Баянбуурал дэлгүүрийн эзэн                      |
| 60 | Төмөр Цэцэгмаа            | Арбулаг сумын ЭМТ-ийн их эмч                                |
| 61 | Балжинням Цогоосүрэн      | Арбулаг сумын ЕБС-ийн тогооч                                |
| 62 | Алтангэрэл Идэржаргал     | Нэгдсэн эмнэлгийн сувилахуйн арга зүйч                      |
| 63 | Цэрэндорж Загдсүрэн       | Хаан банкны Хөвсгөл салбарын тооцооны төв хариуцсан менежер |
| 64 | Дүгэр Болдбаатар          | Эрдмийн далай цогцолбор сургуулийн биеийн тамирын багш      |

#### Б. Аймгийн Засаг даргын Жуух бичиг

|    |                          |  |
|----|--------------------------|--|
| 01 | Норжмаа Гарамжав         | Мөрөн сумын 12 багийн өндөр настан                     |
| 02 | Батжанцан Цэгмид         | Мөрөн сумын 12 багийн өндөр настан                     |
| 03 | Батбаяр Норовбадам       | Бүрэнтогтох сумын ЕБС-ийн байрын жижүүр                |
| 04 | Түмэндэмбэрэл Даваасүрэн | ДМЦС-ийн түүх нийгмийн багш                            |
| 05 | Г.Давааноров             | Титэм ЕБС-ийн биеийн тамирын багш                      |
| 06 | Э.Энхсайхан              | Авъяас сургуулийн биеийн тамирын багш                  |
| 07 | Ж.Өлзий                  | Баянзурх сумын иргэн                                   |
| 08 | И.Бажир                  | Баянзурх сумын иргэн                                   |
| 09 | Сандагдорж Баттулга      | Хатгал тосгоны иргэн                                   |
| 10 | Сүрэн Мөнгөнцэцэг        | Арбулаг сумын 4-р багийн малчин                        |
| 11 | Хорлоо Баярсайхан        | Мөрөнгийн хүрээ Гандандаржаалин хийдийн гүрэм засалч   |
| 12 | Энхбат Лхагва-Очир       | Мөрөнгийн хүрээ Гандандаржаалин хийдийн их унзад       |
| 13 | Ганболд Ганчимэг         | Шинэ -Идэр сумын 1-р багийн ахмад                      |
| 14 | Сосор Шагдарсүрэн        | Шинэ -Идэр сумын 5-р багийн ахмад                      |
| 15 | Энхболд Энхбаяр          | Шинэ -Идэр сумын 2-р багийн ахмад                      |
| 16 | Гантөмөр Солонго         | Алаг-Эрдэнэ сумын Хөгжил хүүхдийн цэцэрлэгийн үйлчлэгч |
| 17 | Бат-Очир Урангоо         | Цэцэрлэг сумын ЕБС-ийн тогооч                          |
| 18 | Энхцэцэг Battөгс         | Хатгал тосгон Хаан банкны теллэр                       |
| 19 | Лувсан Даариймаа         | Хатгал тосгоны 6-р багийн малчин                       |
| 20 | Ганбаатар Мөнхбаяр       | Хатгал тосгоны 6-р багийн малчин                       |
| 21 | Дэндэв Дащцэрэн          | Цэцэрлэг сумын ахмад настан                            |
| 22 | Пүрэвжав Уранчимэг       | Цэцэрлэг сумын ахмад настан                            |
| 23 | Төмөрөө Баасанхүү        | Цэцэрлэг сумын ахмад настан                            |
| 24 | Бат-Эрдэнэ Аюуш          | Тариалан сумын ахмад настан                            |
| 25 | Дана Алтанцэцэг          | Тариалан сумын ахмад настан                            |
| 26 | Дэмчигдорж Отгонцэцэг    | Төмөрбулаг сумын ЕБС-ийн англи хэлний багш             |
| 27 | Сүхбаатар Ганбаяр        | Түнэл сумын 4-р багийн малчин                          |
| 28 | Батсүрэн Сарантуяа       | Түнэл сумын 2-р багийн малчин                          |

|    |                         |   |
|----|-------------------------|---|
| 29 | Ренчиндорж Энхтуяа      | Түнэл сумын 6-р багийн малчин   |
| 30 | Мөнхбаяр Аззаяа         | Хөгжимт драмын театрны жужигчин   |
| 31 | Шагдар Чагцалмаа        | Цагаан-Уул сумын Өвгөд багийн малчин  |
| 32 | Бадамжав Цэнд-Аюуш      | Цагаан-Уул сумын 3-р багийн малчин  |
| 33 | Цэрэндиваа Гансух       | Практикал даатгалын төлөөлөгч   |
| 34 | Баасанцэрэн Анхбаяр     | Ханх сумын 2-р багийн Засаг дарга   |
| 35 | Даваасурэн Отгонбаяр    | Ханх сумын 3-р багийн Засаг дарга   |
| 36 | Зинамядар Оюунцэцэг     | Гурван ивээл" ХХК-д савлагч   |
| 37 | Мөнхтайван Ариунтуяа    | Бүрэнтогтох сумын ЕБС-ийн нийгмийн ажилтан  |
| 38 | Ёндөнжамц Баярхүү       | Бүрэнтогтох сумын соёлын төвийн галч  |
| 39 | Бавуудорж Мөнхгэрэл     | Бүрэнтогтох сумын ЕБС-ийн хөгжмийн багш   |
| 40 | Ням-Очир Дэнсмаа        | Алаг-Эрдэнэ сумын 1-р багийн малчин   |
| 41 | Шарав Цэрэннадмид       | Жаргалант сумын ЕБС-ийн ахмад номын санч  |
| 42 | Ядамцоо Энхжаргал       | Их-Уул сумын 3-р багийн ахмад настан  |
| 43 | Жанчивсамбуу Дондовоо   | Жаргалант сумын ЕБС-ийн ахмад багш  |
| 44 | Дүнгээ Навчaa           | Түнэл сумын ЗДТГ-ын дотоод ажилтан  |
| 45 | Эрдэнэбаатар Бурмаа     | Чандмань-Өндөр сумын ЗДТГ-ын дотоод ажилтан   |
| 46 | Чинбат Батцэцэг         | "Тэс гүн" ХХК-ийн цехийн ажилтан  |
| 47 | Дашжамц Цогзолмаа       | Хилийн 0257-р ангийн ахлах офицер   |
| 48 | Батмөнх Янжмаа          | ШШГА-ны ахлах ахлагч  |
| 49 | Чулуунбаатар Гомбосурэн | ШШГА-ны ахлах ахлагч  |
| 50 | Дулмаа Төмөрхуяг        | ШША-ны туслах ажилтан   |
| 51 | Мягмар Батбаатар        | ОБГ-ын гал сөнөөгч  |
| 52 | Нэргүйцоо Анхбаяр       | Тагнуулын ахлах ажилтан, ахмад  |
| 53 | Дорж Пүрэвсүрэн         | Цагдаагийн газрын ахлах ахлагч  |
| 54 | Пүрэвжав Баярмаа        | ЭМГ-ын мэдээ мэдээлэл хариуцсан мэргэжилтэн   |
| 55 | Зоригт Очирбаяр         | Цээнэ эмнэлгийн эмч   |
| 56 | Сумьяадаш Туяа          | Энэрэл ӨЭМТ-ийн их эмч  |
| 57 | Чойдон Болдбаатар       | Нэгдсэн эмнэлгийн дурс оношлогооны эмч  |
| 58 | Энх-Амгалан Инжир       | Нэгдсэн эмнэлгийн төрөх тасгийн эх баригч эмч                                       |
| 59 | Пүрэв-Ойдов Түмэнжаргал | Нэгдсэн эмнэлгийн мэдээгүйжүүлэгч эрчимт эмчилгээний эмч                            |
| 60 | Магсар Лхагвадулам      | Энх-үйлс ӨЭМТ-ийн их эмч  |
| 61 | Гэлэнхүү Пүрэвдорж      | Их-Уул сумын ЕБС-ийн байрын багш  |
| 62 | Гал-Эрдэнэ Хашбат       | Арбулаг сумын ЕБС-ийн байрын багш   |
| 63 | Батсайхан Ганболд       | Алаг-Эрдэнэ сумын ЕБС-ийн жижүүр  |
| 64 | Гөхгөө Нямхүү           | Бүрэнтогтох сумын Баянхошуу багийн ахмад  |
| 65 | Б.Дашцэрэн              | Жаргалант сумын худалдаа эрхлэгч  |
| 66 | Агаан Түмэндэмбэрэл     | Бүрэнтогтох сумын худалдаа эрхлэгч  |
| 67 | Лхагвасүрэн Тайван      | Нэгдсэн эмнэлгийн Сэтгэцийн эрүүл мэнд, сэтгэл зүйн тусlamж үзүүлэх төвийн сувилагч |
| 68 | Бат Сэргэлэн            | Арбулаг сумын ЭМТ-ийн жолооч  |
| 69 | Батсайхан Нацагдорж     | Арбулаг сумын ЕБС-ийн багш  |
| 70 | Цэрэндэжид Энх-Учрал    | Нэгдсэн эмнэлгийн Дурс оношлогооны тасгийн техникч                                  |
| 71 | Дагва Түвшинжаргал      | Нэгдсэн эмнэлгийн эмэгтэйчүүдийн тасгийн эх баригч эмч                              |
| 72 | Нямаа Майцэцэг          | Хаан банкны Ханх тооцооны төвийн харилцааны менежер                                 |
| 73 | Лхүндэв Мөнгөншагай     | Их -Уул сумын ЕБС-ийн биеийн тамирын багш   |

В. Аймгийн Засаг даргын Тамгын Газрын даргын Баярын бичиг

|    |            |  |
|----|------------|--|
| 01 | М.Болормаа | Алаг-Эрдэнэ ЕБС-ийн англи хэлний багш  |
| 02 | Б.Одгэрэл  | Рашаант сумын ЕБС-ийн нийгмийн ажилтан |

|    |                        |   |
|----|------------------------|---|
| 03 | Ц.Цэнд-Аюуш            | Гурван эрдэнэ ЕБС-ийн нийгмийн ажилтан                      |
| 04 | Батсайхан Энэбиш       | Бүрэнтогтох сумын ЕБС-ийн жижүүр                            |
| 05 | Лутбаяр Болдбаатар     | Бүрэнтогтох сумын ЕБС-ийн ажилтан                           |
| 06 | Ширбазар Гэрэлцэцэг    | Алаг-Эрдэнэ сумын 2-р багийн малчин                         |
| 07 | Гэндэн Бутэд           | Алаг-Эрдэнэ сумын 3-р багийн малчин                         |
| 08 | Моохууз Даваацэцэг     | Арбулаг сумын ЗДТГ-ын үйлчлэгч                              |
| 09 | Баяраа Ганбаатар       | Шинэ-Идэр сумын СДЭ-ийн галч                                |
| 10 | Мөнхөө Буджав          | Хатгал тосгоны Төрийн банкны эрхлэгч                        |
| 11 | Майбаяр Оюунтунгалаг   | Хатгал тосгоны НАМЗХ-ийн гишүүн                             |
| 12 | Пүрэвцогт Баяртуяа     | Хатгал тосгоны НАМЗХ-ийн гишүүн                             |
| 13 | Нямдорж Лхагвабаяр     | Хатгал тосгоны НАМЗХ-ийн гишүүн                             |
| 14 | Батбаатар Шархүү       | Түнэл сумын 6-р багийн малчин                               |
| 15 | Шархүү Отгонжаргал     | Ханх сумын 1-р багийн Засаг дарга                           |
| 16 | Галзагд Шинэжаргал     | Түнэл сумын 4-р багийн малчин                               |
| 17 | Арьяа Тунгалаг         | Түнэл сумын 6-р багийн малчин                               |
| 18 | Чадраабал Долгор       | Цагаан-Уул сумын Агар багийн малчин                         |
| 19 | Долзод Цэгээнсүрэн     | Цагаан-Уул сумын Жаргалант багийн малчин                    |
| 20 | Бадрах Батмөнх         | Практикал даатгалын төлөөлөгч                               |
| 21 | Ганбат Мөнх-Учрал      | Бүрэнтогтох сумын ЭМТ-ийн сувилагч                          |
| 22 | Ганболд Цасанболор     | Бүрэнтогтох сумын хүүхдийн цэцэрлэгийн туслах багш          |
| 23 | Батдорж Даариймаа      | Бүрэнтогтох сумын ЕБС-ийн байрын багш                       |
| 24 | Ширбазар Гэрэлцэцэг    | Алаг-Эрдэнэ сумын 2-р багийн малчин                         |
| 25 | Маншир Нямдаваа        | Алаг-Эрдэнэ сумын 1-р багийн малчин                         |
| 26 | Осоржин Доржпагмажав   | Галт сумын ЕБС-ийн ахмад багш                               |
| 27 | Гомбо Долгор           | Түнэл сумын 6-р багийн ахмад настан                         |
| 28 | Оюунгэрэл Золзаяа      | Ханх сумын ЗДТГ-ын дотоод ажилтан                           |
| 29 | Ганбаатар Уранцэцэг    | Баянзүрх сумын ЗДТГ-ын дотоод ажилтан                       |
| 30 | Баяраа Ичинхорлоо      | 321-р салбарын аж ахуйн дарга                               |
| 31 | Долгорсүрэн Энхдалай   | ОБГ-ын жолооч, ахлах ахлагч                                 |
| 32 | Дорж Сүрэн             | ШШГА-ны сувилагч, ахлах ахлагч                              |
| 33 | Энхсүрэн Нямжав        | ШША-ны туслах ажилтан                                       |
| 34 | Түмэн Мөнх-Очир        | Тагнуулын газрын оператор, ахлах дэслэгч                    |
| 35 | Дорж Энхбаатар         | Цагдаагийн газрын мөрдөн байцаагч, дэслэгч                  |
- Санхүү, мөнгөний удирдлагыг сайжруулж үр ашгийг дээшлүүлэх
- Гадаад, дотоод төсөл хөтөлбөрийн эдийн засгийн нэгдсэн удирдлага уялдаа холбоог сайжруулах
- Байгууллагын нягтлан бодох бүртгэлийн ажлыг оновчтой төлөвлөн, зохион байгуулж, ажиллагсдын нийгмийн баталгааг нэмэгдүүлэх
- Өмч хөрөнгийн хадгалалт хамгаалалт, ашиглалтыг сайжруулах
- Санхүү, эдийн засгийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах.
- Боловсролын салбарын байгууллагуудыг санхүү, нягтлан бодох бүртгэлийн удирдлагаар хангах, нягтлан бодох бүртгэлийн ажилтнуудад мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, тэдний үйл ажиллагааг нь үнэлэх дүгнэх
- Байгууллагын тохижилт, үйлчилгээний ажлыг хариуцах
- Байгууллагын сантехник, дулаан, цахилгааны хэвийн ажиллагааг хангуулах өдөр тутмын асуудлыг шийдвэрлэх
- БСУГазрын албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг хөтлөн явуулах;
- Ирсэн албан бичиг болон ирүүлсэн баримт бичгийг цахим шуудангаар дамжуулан хүргэх;
- Албажуулахаар ирүүлсэн материалыг төрийн албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар, бичиг хэргийн стандартын дагуу бичих, хянах, хэвлэх;
- Иргэд, байгууллагаас ирүүлсэн болон иргэдээс гаргасан өргөдөл, санал, гомдлыгхүлээнавчбүртгэншийдвэрлүүлэх.
- Архивын бүрдүүлэлт, тоо бүртгэл, хадгалалт хамгаалалт, ашиглалтын үйл ажиллагааг журам, зааврын дагуу зохион байгуулах;
- Байгууллага, иргэдийн хүсэлтээр архивын баримтын хуулбар, лавлагаа олгох;
- Газрын цахим архив бүрдүүлэх ажлыг зохион байгуулах

- Газрын ажилтанд архив, албан хэрэг хөтлөлтийн талаар мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх.

### **ХӨГЖҮҮЛЭХ БАГ**

#### **Хамтран ажиллах хүрээнд:**

- Боловсролын сургалтын чанар, хэрэгжилт, багшийн хөгжлийн чиглэлийг үнэн зөв тодорхойлж ажиллах
- Судлах, оношилох, үйл ажиллагааны хазайлтыг гаргах, хазайлтад нөлөөлөх хүчин зүйлсийг тодруулах, шинэ санал оюун дүгнэлт боловсруулахад хамтран ажиллах
- Боловсролын талаар тавигдсан үндсэн чиг үүргүүдийг хангах, цөм хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд боловсролын чанарын хэрэгжилт, мэдлэгийн түвшинд үнэлгээ хийх, төлөвлөн зохион байгуулах, дүгнэлт гаргахад хамтран ажиллах, шаардлагатай мэдээ мэдээллээр үйлчлэх
- Боловсролын бодлого үйл ажиллагаанд иргэд олон нийтийн оролцоо сэтгэл ханамжийн үнэлгээг хийх, хамтран ажиллах, нэгдэх, багшийн ажлыг үнэн зөв үнэлж дүгнэх мэргэжлийн нэр хүндийг өсгөх боломж бүрдүүлэхэд хамтран ажиллана.
- Багш нарын болон сурагчдын олимпиад уралдааныг зохион байгуулах, үнэлж дүгнэх
- Багшийн хөгжил, сурагчийн сурлагын амжилт хөгжлийн талаар мэдээллийн сан бүрдүүлэх, сэтгэл ханамжийн үнэлгээ хийх, дүгнэлт гаргахад хамтран ажиллана
- БСУГ –нь:** Багшийн мэрэгжил арга зүй урчадварыг суралцагчдын хөгжлөөр үнэлдэг, урамшуулдаг, гүйцэтгэлд сууринсан байхад үнэлгээний багийн үйл ажиллагаа дүгнэлтийг ашиглана

### **ТҮГЭЭН ДЭЛГЭРҮҮЛЭХ БАГ**

#### **Хамтран ажиллах хүрээнд:**

- Хөгжүүлэх багийн гаргасан дүгнэлтэд үндэслэн аль нэг түвшний үр өгөөжийг нэмэгдүүлэх сургалтын чанарыг дэмжих, багшийн манллайлын ур чадварыг дэмжих, сургалт зохион байгуулах үлгэрлэх зорилготой зорилтод баг
- Хүний хөгжлийг хангах үүрэгтэйгээр хүрээг өргөтгөн бэхжүүлнэ.
- Ерөнхий боловсролын сургалтын чанар, өрсөлдөх чадварын жишгийг тогтоох чиг үүргийг хэрэгжүүлэхэд үлгэрлэн ажиллана
- ЕБС бүрийн тулгамдсан асуудалд дүн шинжилгээ хийж шаардлагатай сургалт арга зүйн дэмжлэгээр хангаж ажиллах
- Эцэг, эх боловсролын талаар мэдээ, мэдээлэл хүргэх, харилцаа хандлага сурган хүмүүжүүлэх хандлагад дэмжлэг үзүүлэх
- Сурагчийн сурх арга барил хандлагыг өөрчлөх

- Багшийн мэргэжлийн ур чадварыг ахиулах сургалт зохион байгуулах, нээлттэй хичээл заах, тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэхэд жишиг бүтээл хийж түгээн дэлгэрүүлэх
- Сургууль, бүсийн үйл ажиллагаанд оролцож хэрэгцээтэй мэдээлэл, үйл ажиллагаагаар түгээн дэлгэрүүлэх
- **БСУГ –нь :** Сургууль бүрт хүрч ажиллахад дэмжлэг авна.

## ЗӨВЛӨН ТУСЛАХ БАГ

### **Хамтран ажиллах хүрээнд:**

- БСУГ –аас болон бүсийн үйл ажиллагаа, 1, 5,10 жилийн сургалтын багш нь зөвлөн туслах үүрэгтэй ажиллана.
- Аймаг, улс, бүс сургуулийн ур чадварын аварга багш нар зөвлөн туслах үүрэг хүлээнэ
- Судалгаат хичээл, хэлэлцүүлэг хийх, сайн хичээл, үйл ажиллагааны зөвлөгөөн зохион байгуулахад хамтран ажиллах багш бүрт шаардлагатай мэдлэг мэдээллээр зөвлөн тусална
- Улирал бүр сургууль бүрээс хөтөлбөр ирүүлэх хүсэлт тавьж хөтөлбөр боловсруулалтад зөвлөн тусална
- Түгээн дэлгэрүүлэх багт хамтран ажиллах зөвлөн туслах шаардлагатай чиглэлийг өгч ажиллана
- Хөгжүүлэх багийн дүгнэлтэд үндэслэн сургуулиудтай хамтран ажиллаж хичээлд сууж зөвлөгөө өгнө
- Мэргэжил арга зүйн зохион байгуулалтаар хангана
- Зохион байгуулсан хичээл бүрийн тэмдэглэл хөтлөх, хэлэлцэх, дүгнэлт гаргах ажлыг БСУГ-ын мэрэгжилтэн болон сургалтын менеээрүүдтэй хамтран зохион байгуулна
- БУСГ-ын санал хүсэлтээр сургуулиуд дээр ажиллаж дүгнэлт гаргах, зөвлөн туслах ажлыг хийнэ
- **БСУГ –нь:** Багшийн шинэ арга зүй, сайн арга туршлага, үр дүн сурагчдын массын сургалтын чанарыг бодитоор нээн илрүүлэхэд дүгнэлтийг ашиглана.

### **Тав.Зохион байгуулалт, үйл ажиллагааны хүрээ**

5.1.Боловсрол, соёл, урлагийн газар нь Бодлого төлөвлөлтийн, ЕБС, СӨБ-ын арга зүйн, Санхүү үйлчилгээний хэлтэс, Насан туршийн боловсролын, Соёл, урлагийн хэлтэстэй байна. Бодлого, төлөвлөлтийн хэлтэс нь дотроо хяналт үнэлгээ, дотоод аудитын болон судалгаа мэдээллийн албатай байна.

5.2.Газрын даргыг Боловсрол, соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцсөний үндсэн дээр аймгийн Засаг дарга томилж, чөлөөлнө.

5.3. Газрын дарга, мэргэжилтэн нь бакалавр түүнтэй адилтгах болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй, боловсролын сургалтын байгууллагад сүүлийн 5 жил ажилласан туршлагатай, багш ажилтанд мэргэжлийн зөвлөгөө, арга зүйн мэргэшсэн үйлчилгээ үзүүлэх, судалгаа хийх, мэдээлэл боловсруулах болон багаар ажиллах ур чадвартай байх бөгөөд харилцааны соёл, ёс зүйн хэм хэмжээ сахин ажиллана.

5.4. Газрын дарга нь бусад хууль тогтоомжид заасны дагуу байгууллагын дарга, төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх чиг үүргийн хэрэгжилтийг ханган ажиллана.

5.5. БСҮГ-ын хэлтсүүдийн дарга, мэргэжилтэнг ажлын байрны тодорхойлолтод тавигдсан шалгуурын дагуу сонгон шалгаруулж, газрын дарга томилж чөлөөлнө.

5.6. Хэлтсийн дарга, мэргэжилтэн, ажилчдын ажлын байрны тодорхойлолтуудыг газрын дарга баталж мөрдүүлнэ.

5.7. Боловсрол, соёл, урлагийн газарын Бодлого, төлөвлөлтийн, ЕБС, СӨБ-ын арга зүйн, Санхүү үйлчилгээний хэлтэс, Насан туршийн боловсролын, Соёл, урлагийн хэлтсийн дарга, мэргэжилтнүүд нь тухайн салбарын төрийн болон орон нутгийн бодлогыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, биелэлтэд хяналт тавих, үр дүнд үнэлгээ өгөх, орон нутгийн байгууллагуудыг мэргэжлийн боловсон хүчинээр хангах, сургууль цэцэрлэгийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх, үнэлгээ өгөх ажлыг зохион байгуулна.

5.8. Санхүү, үйлчилгээний хэлтэсийн дарга, төсөв, хөрөнгө оруулалт хариуцсан ахлах мэргэжилтэн нь Боловсролын байгууллагын эдийн засаг, санхүүгийн удирдлага болон стратеги төлөвлөлт, тухайн жилийн төсвийг төлөвлөх, төсвийн гүйцэтгэл, нягтлан бодох бүртгэлийн хэрэгжилтийг зохицуулах, хяналт шинжилгээ хийх, тайлан балансыг хянах, зохих хууль тогтоомжийн дагуу тайлагнана.

5.9. Хэлтсийн дарга нар нь боловсролын байгууллагуудыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, зөвлөн туслах, тэдний мэргэжлийг дээшлүүлэх ажлын төлөвлөлтийг хийж, боловсролын салбарын статистик, мэдээ тайланг гаргаж, холбогдох байгууллагад хүргүүлэх ажлыг зохион байгуулалтаар хангаж, мэргэжилтнүүдийг удирдан ажиллана.

5.10. Боловсрол, соёлын үйл ажиллагааг олон нийтийн оролцоо, түншлэлд тулгуурлан шударга, хүртээмжтэй, ил тод нээлттэй, тэгш байдлыг ханган явуулна.

5.11. Мэргэжилтэн нь мэргэжил давхцахгүй байна.

### **Зургаа. Эрх, үүрэг**

6.1. Газар нь дор дурьдсан эрхтэй.

6.1.1.Боловсрол, соёлын хөгжлийн асуудлаар холбогдох байгууллага, хүмүүст санал тавьж шийдвэрлүүлэх.

6.1.2.Батлагдсан төсөвт багтааж бүтэц, орон тоогоо тогтоох

6.2.Газар нь дараах үүрэгтэй.

6.2.1.Нутаг дэвсгэрийнхээ боловсрол, соёлын байгууллагын үйл ажиллагааг мэргэжил арга зүйн болон захиргааны удирдлагаар хангах, үйл ажиллагаанд нь хяналт-шинжилгээ хийж үнэлгээ өгөх.

6.2.2.Захирал, цэцэрлэгийн эрхлэгч, сургалтын менежер, цэцэрлэгийн арга зүйчдийг томилох, чөлөөлөх санал, дүгнэлтийг аймгийн Засаг даргад болон сургууль, цэцэрлэгийн захирал, эрхлэгчдэд гаргах багшийг сургууль, цэцэрлэг томилуулах, санал өгөх багшийг аттестатчилах, нөөцөд бүртгэх, багшид мэргэжлийн болон багшлах эрх олгох, хасахад санал дүгнэлт гаргах.

6.2.3..Боловсрол, соёлын ажилтны нийгмийн баталгааг сайжруулах, байгууллага, ажилтнуудын хөдөлмөрийг үнэлэх, шагнаж урамшуулах бусад дэмжлэг үзүүлэх

6.2.4.Орон нутгийн боловсрол, соёлын хөгжлийн бодлогод нийцүүлэн санхүүгийн нөөцөө оновчтой хуваарилан байршуулж, төсвөө бодитой төлөвлөх, санхүүгийн гүйцэтгэлийн тайланг шаардлагын дагуу үнэн зөв гаргаж, холбогдох байгууллагуудад мэдээлж тайлагнах.

6.2.5.Төсвийн тухай хуулийн дагуу үйл ажиллагааныхаа үр дүнг аймгийн Засаг дарга болон Боловсрол, соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлагнах, бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээгээ дүгнүүлэх.

6.2.6.Боловсрол, соёлын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад статистик мэдээг зохих стандартын дагуу хугацаанд нь үнэн зөв гаргаж өгөх, аймгийн Засаг дарга, Засаг даргын Тамгийн газар, Нийгмийн бодлогын хэлтсийг салбарын мэдээллээх хангах.

6.2.7.Боловсрол, соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас гаргаж буй тушаал, шийдвэрийн эмхэтгэлийг орон нутагт татан авах, холбогдох байгууллага, хүмүүст сурталчилах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах.

### **Долоо. Төсөв санхүүгийн талаар.**

7.1.Газар нь үндсэн ба эргэлтийн хөрөнгөтэй байх ба түүнийг зохих хууль тогтоомжийн дагуу зарцуулж ашиглана.

7.2.Газар нь төсөвтэй байх ба дотоод, гадаадын байгууллага иргэдийн тусламж, хандив, гэрээт ажил болон бусад эх үүсвэртэй байна.

7.3.Газрын төсвийг захиран зарцуулахдаа 1 дүгээр гарын үсгийг газрын дарга, 2 дугаар гарын үсгийг ня/ бо зурна.

## ***Найм . Ажлаа тайлагнах***

8.1. Боловсрол, соёл, урлагийн газар нь хагас бүтэн жилээр боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон аймгийн Засаг даргаар ажлаа дүгнүүлнэ.

8.2. Аймгийн Засаг даргаас Боловсрол, соёл, урлагийн газрын даргатай байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлтийг хагас бүтэн жилээр гаргаж Нийгмийн бодлогын хэлтэст ирүүлнэ.

8.3. Мэргэжилтэн ажилтнууд нь нь хэлтсийн даргад жилд 2 удаа, сургууль багш нарт 1-ээс доошгүй удаа ажлаа тайлагнаж, дүн үнэлгээг байгууллагын даргаар баталгажуулна. Хэлтсийн дарга нарт газрын даргад жилд 2 удаа ажлаа тайлагнаж, үнэлүүлнэ.

ооо



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2018 оны 01 сарын 22 өдөр

Дугаар A/46

Мөрөн

Төлөвлөгөө батлах түхай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-гийн "а", 29.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 36 дугаар зүйлийн 36.6, Сангийн сайдын 2014 оны 65 дугаар тушаал, 2012 оны 239 дүгээр тушаалын 2.1.3 заалтыг тус тус үндэслэн

**ЗАХИРАМЖЛАХ** нь:

1. 2018 онд сумдын төрийн сангийн үйл ажиллагаанд дотоод хяналт хийх, сумын төсөвт байгууллагуудад хяналт шалгалт хийх, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх төлөвлөгөөг нэгдүгээр хавсралт, сумдад хяналт шалгалт хийх, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэхэд шаардагдах зардлыг хөёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Сумдын төрийн сангийн нэгжийн үйл ажиллагаанд болон төсөвт байгууллагуудад хяналт шалгалт хийх удирдамжийг салбар бүрээр тусгайлан боловсруулж, баталсан төлөвлөөний дагуу сумдад ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Г.Сувд/-д үүрэг болгосугай.

3. Холбогdon гарах шатахууны зардал 898,900 /Найман зуун ерэн найман мянга есөн зуу/ төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Х.Ган-Очир/-д зөвшөөрсүгэй.



Zahiramj-2018-A/46  
01110076

Аймгийн Засаг даргын 2018 оны 01 дүгээр  
сарын 22-ны өдрийн А/46 дугаар  
захирамжийн Нэгдүгээр хавсралт

СУМАНД АЖИЛЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

| №  | Сумын нэр      | Хугацаа       |
|----|----------------|---------------|
| 1  | Тосонцэнгэл    | 6-р сард      |
| 2  | Тариалан       |               |
| 3  | Эрдэнэбулган   |               |
| 4  | Цагаан-үүр     |               |
| 5  | Чандмань-Өндөр |               |
| 6  | Түнэл          |               |
| 7  | Алаг-Эрдэнэ    | 3 дугаар сард |
| 8  | Хатгал         |               |
| 9  | Ханх           |               |
| 10 | Цэцэрлэг       | 4-р сард      |
| 11 | Цагааннуур     | 5-р сард      |
| 12 | Улаан-Уул      |               |
| 13 | Мөрөн          | 3 дугаар сард |

Аймгийн Засаг даргын 2018 оны 01 дүгээр  
сарын 22-ны өдрийн А/46 дугаар  
захирамжийн хоёрдугаар хавсралт

СУМАНД АЖИЛЛАХАД ШААРДАГДАХ ТОССӨВ

20180073071154

| №        | Явах сум     | Шатахуун зардлын тооцоо |          |            | Автомашин |
|----------|--------------|-------------------------|----------|------------|-----------|
|          |              | Явах км                 | Шатахуун | Мөнгөн дүн |           |
| 1        | Тосонцэнгэл  | 520                     | 130      | 231400     | БСУГазар  |
| 2        | Тариалан     |                         |          |            |           |
| 3        | Эрдэнэбулган |                         |          |            |           |
| 4        | Цагаан-үүр   |                         |          |            |           |
| 5        | Чандмань-    |                         |          |            |           |
| 6        | Өндөр        |                         |          |            |           |
| 7        | Түнэл        | 580                     | 145      | 258,100.0  | ЭМГ       |
| 8        | Алаг-Эрдэнэ  |                         |          |            |           |
| 9        | Хатгал       |                         |          |            |           |
| 10       | Ханх         | 420                     | 105      | 186,900.0  | СХАА      |
| 11       | Цэцэрлэг     |                         |          |            |           |
| 12       | Цагааннуур   | 500                     |          | 222,500    | АЗДТГазар |
| 13       | Улаан-Уул    |                         |          |            |           |
| Мөрөн    |              |                         |          |            |           |
| Нийт дүн |              |                         |          | 898,900    |           |



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2018 оны 01 сарын 22 өдөр

Дугаар 147

Мөрөн

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5-ын “а”, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийн 47.1, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.1 дэх заалтууд, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны A/008 дугаар тушаал, Сангийн сайдын 2014 оны 212 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Тосонцэнгэл суманд барих 2,500,000,000 (Хоёр тэрбум таван зуун сая) төгрөгийн төсөвт өртөг бүхий 320 хүүхдийн сургуулийн барилгын угсралтын ажил нийлүүлэх гүйцэтгэгч сонгох үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Үнэлгээний хорооны дарга: Э.Аззаяа-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч

Гишүүд: Н.Шинэбаяр-Аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын мэргэжилтэн

Ц.Нямдорж-Аймгийн Инженерүүдийн холбооны төлөөлөл  
У.Ариунаа-“Хөвсгөл Ус суваг” ХХК-ийн инженер

Нарийн бичгийн дарга: Ц.Эрдэнэбаатар-Аймгийн Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах ажиллагааны хэлтсийн мэргэжилтэн

2. Худалдан авах ажиллагааг хууль тогтоомж, батлагдсан төлөвлөгөөний дагуу зохион байгуулахыг үнэлгээний хорооны дарга (Э.Аззаяа)-д даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга (Б.Болд)-д үүрэг болжосугай.

ДАРГА

Л.ГАНБОЛД

091100780 d:/zahiramj



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2018 оны 01 сарын 22 өдөр

Дугаар А48

Мөрөн

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5-ын "а", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийн 47.1, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.1 дэх заалтууд, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны A/008 дугаар тушаал, Сангийн сайдын 2014 оны 212 дугаар тушаалыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Төмөрбулаг суманд барих 2,500,000,000 (Хоёр тэрбум таван зуун сая) төгрөгийн төсөвт өртөг бүхий 320 хүүхдийн сургуулийн барилгын угсралтын ажил нийлүүлэх гүйцэтгэгч сонгох үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Үнэлгээний хорооны дарга: Ж.Ганболд-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга

Гишүүд: Н.Шинэбаяр-Аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын мэргэжилтэн

Д.Отгонбаяр-“Хөвсгөл Эрчим хүч” ХХК-ийн ерөнхий инженер

У.Ариунаа-“Хөвсгөл Ус суваг” ХХК-ийн инженер


Нарийн бичгийн дарга: З.Батбаяр-Аймгийн Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах ажиллагааны хэлтсийн мэргэжилтэн

2. Худалдан авах ажиллагааг хууль тогтоомж, батлагдсан төлөвлөгөөний дагуу зохион байгуулахыг үнэлгээний хорооны дарга (Ж.Ганболд)-д даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга (Б.Болд)-д уурэг болгосугай.

ДАРГА

Л.ГАНБОЛД



. 0110078 d:/zahiramj



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2018 оны 01 сарын 22 өдөр

Дугаар A|49

Мөрөн

Орон тооны бус зөвлөл байгуулах  
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29.2, Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 195 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Албадлагын арга хэмжээ авсантай холбоотой хураан авсан эд зүйл, хэрэгслийг үнэлэх, худалдан борлуулах, устгах талаар шийдвэр гаргах, хяналт тавих чиг үүрэг бүхий Засаг даргын дэргэдэх захиргааны орон тооны бус зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Зөвлөлийн дарга – Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга  
Гишүүд:

- Орон нутгийн өмчийн газрын Өмчийн хэлтсийн дарга
- Цагдаагийн газрын Нийтийн хэв журам хамгаалах тасгийн дарга
- Аймгийн ЗДТГ-ын Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлогын хэлтсийн ахлах мэргэжилтэн
- Аймгийн ЗДТГ-ын Санхүү төрийн сангийн хэлтсийн нягтлан бодох бүртгэлийн мэргэжилтэн
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны 102 дугаар тойргийн шийдвэр гүйцэтгэгч

Нарийн бичгийн дарга – Мэргэжлийн хяналтын газрын Төрийн захиргаа, эрсдэлийн удирдлагын хэлтсийн дарга

2. Энэхүү захирамж болон “Албадлагын арга хэмжээ авсантай холбоотой хураан авсан, хөрөнгө, орлого, эд зүйл, хэрэгслээс хохирол нөхөн төлүүлэх, улсын орлого болгох, устгах журам”-ыг хэрэгжүүлж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга бөгөөд Засаг даргын дэргэдэх захиргааны орон тооны бус зөвлөлийн дарга (Х.Ган-Очир)-д үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Дэд бүтэц, хөрөнгө оруулалт хариуцсан орлогч (Ц.Баттогтох)-д даалгасугай.

ДАРГА

Л.ГАНБОЛД





МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2018 оны 01 сарын 23 өдөр


Дугаар A/50

Мөрөн

Цэцэрлэгт бүлэг нэмж ажиллуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5-ын "а" заалт, Боловсролын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Рэнчинлхүмбэ, Рашиант, Галт, Шинэ-Идэр сумын хүүхдийн цэцэрлэгт тус бүр нэг бүлэг шинээр нэмж ажиллуулсугай.
2. Дээрх цэцэрлэгүүдэд бүлэг нэмсэнтэй холбогdon гарах зардлыг санхүүжүүлж ажиллахыг Боловсрол, соёл, урлагийн газрын даргын албан ўргийг түр орлон гүйцэтгэгч (Я.Дашзэвэг)-д даалгасугай.
3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын дарга (Х.Ган-Очир)-д даалгасугай.





МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2018 оны 01 сарын 24 өдөр

Дугаар A/51

Мөрөн

Тусгай зөвшөөрлийг сунгах, хүчингүй болгох,  
түдгэлзүүлэх, сэргээх, захирамжинд нэмэлт  
өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29.1.6-ын "г" 29.3 дахь заалт, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.4, 10.1.5, 13 дугаар зүйлийн 13.1, 13.3, 14 дүгээр зүйлийн 14.1.1, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.17, 19.18 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлийг сунгах аж, ахуйн нэгж байгууллагын жагсаалтыг 1 дүгээр, тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох аж ахуйн нэгж байгууллагын жагсаалтыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн зохих шаардлага, MNS 5095-2013 нэгдсэн эмнэлгийн бүтэц үйл ажиллагааны стандартын зохих шаардлага хангаагүй, "Төгс Монгол Ану" ХХК-ийн Төгс дент, "Түгээмэл сайхан" ХХК-ийн Сайхан, "Хязгааргүй энх"ХХК-ийн Хязгааргүй гэрэл эмнэлэг, MNS 5530-2014 эрүүл эмнэдийн технологи, Эм эмнэлгийн хэрэгсийн хадгалалт түгээлтэнд тавих ерөнхий шаардлага стандартын зохих шаардлага хангаагүй Азиифарма, Монфа эм ханганд нийлүүлэх байгуулга, Цэцэрлэг сумын Бүрхээр багийн Ариун жугтай эмийн сангийн үйл ажиллагааг 3 сарын хугацаагаар түдгэлзүүлсүгэй.

3. Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаанд тавьсан зохих шаардлагыг хангаж, зөрчлийг арилгасан "Их-Отгонтэнгэр" ХХК-ийн "Отгонтэнгэр" эмийн сан, "Оргил дент" ХХК-ийн Оргил дент эмнэлгийн үйл ажиллагааг сэргээсүгэй.


4. Аймгийн Засаг даргын 2015 оны 07 дугаар сарын 03 өдрийн А/257 дугаар захирамжийн нэгдүгээр хавсралтын 7 дахь заалтыг Мөрөн сумын 8-р баг Циркон эмнэлгийн байранд гэснийг Мөрөн сумын 8-р баг "Тана" эмнэлгийн байранд гэж өөрчилсүгэй.

2.

5. Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үйл ажиллагаанд холбогдох хууль тогтоомжийн дагуу хяналт тавьж ажиллахыг аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга /Д.Лхагвасүрэн/, Эрүүл мэндийн газрын дарга /М.Үүрийнбаяр/ нарт үүрэг болгосугай.

6. Эрүүл мэндийн багц хууль, эрүүл мэндийн байгууллагууд, эмийн сангидад холбогдох хууль тогтооомж, стандартууд, эмнэл зүйн удирдамжуудыг мөрдөж ажиллахыг эрүүл мэндийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд даалгасугай.

7. Энэхүү захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга /Ж.Ганболд/-д үүрэг болгосугай.



Аймгийн Засаг даргын 2018 оны 01 дүгээр  
сарын 24-ний өдрийн А/51 дүгээр захирамжийн  
1 дүгээр хавсралт

**ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ  
АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ БАЙГУУЛЛАГА**

|   | Байгууллагын нэр                                     | Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр | Эрхлэх үйл ажиллагааны чиглэл                       | Ажлын байрны хаяг                    | Тусгай зөвшөөрлийн хугацаа |
|---|--|----------------------------------|---|--------------------------------------|----------------------------|
| 1 | Алтан мэргэд"<br>ХХК-ийн<br>“Алтан дент ”<br>эмнэлэг | Ц.Алтанцэцэг                     | Шүд эрүү нүүрний тусlamж үйлчилгээ, хиймэл шүдэлбэр | Мөрөн сум 8-р баг, 32-р байр 23 тоот | 2018.01.08<br>2023.01.08   |

Аймгийн Засаг даргын 2018 оны 01 дүгээр  
сарын 24-ний өдрийн А/51 дүгээр захирамжийн  
2 дугаар хавсралт

**ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР МЭРГЭЖЛИЙН  
ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ТУСГАИ ЗӨВШӨӨРӨЛ  
ХҮЧИНГҮЙ БОЛГОХ БАЙГУУЛЛАГА**

| № | Байгууллагын нэр  | Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр | Ажлын байрны хаяг                                    | Тусгай зөвшөөрөл анх олгосон захирамжийн огноо                             | Тайлбар   |
|---|-------------------|----------------------------------|--|--|---|
| 1 | Намуун эмнэлэг    | М.Үүрийнбаяр                     | Мөрөн сумын 8 дугаар баг,<br>Жаргалан эмнэлгийн байр | Аймгийн Засаг даргын 2015 оны 257-р захирамжийн 1-р хавсралт 5 дахь багана | Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 14 дүгээр зүйл 14.1.1 тусгай зөвшөөрөл эзэмшигч хүсэлт гаргасан |
| 2 | Эх мэлмий эмнэлэг | Л.Эрдэнэцэцэг                    | Мөрөн сум 8 дугаар баг 18-р байр                     | Аймгийн Засаг даргын 2012 оны 311-р захирамжийн 1-р хавсралт 5 дахь багана |   |
| 3 | Өнөр эмнэлэг      | Б.Энхбилэг                       | Мөрөн сумын 8 дугаар баг, Тана эмнэлгийн байр        | Аймгийн Засаг даргын 2015 оны 149-р захирамжийн 1-р хавсралт 1 дахь багана |   |



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2018 оны 01 сарын 24 өдөр

Дугаар A/52

Мөрөн

Ажлын хэсэг байгуулах  
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29.2, Монгол улсын Засгийн газрын 2017 оны 270 дугаар тогтоолыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч:

- Ж.Ганболд-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга


Гишүүд:

- Д.Цэцэгмаа- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн
- Я.Дашзэвэг- Боловсрол, соёл урлагийн газрын дарга
- Б.Эрдэнэхуяг- Хөдөлмөр, хalamжийн үйлчилгээний газрын дарга
- Ц.Адъяацэрэн- Цагдаагийн газрын дарга
- М.Үүрийнбаяр- Эрүүл мэндийн газрын дарга

Нарийн бичгийн дарга:

- Ч. Дашбаяр- Гэр бүл, хүүхэд, запуучуудын хөгжлийн газрын дарга

2. “Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг 2018 оны 02 дугаар сарын 01-ний дотор боловсруулан аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар батлуулж ажиллахыг ажлын хэсэгт үүрэг болгосугай.



Zahiramj-2018-A/52  
00110102



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2018 оны 01 сарын 24 өдөр

Дугаар A/53

Мерөн

Нийгмийн түншлэлийг хөгжүүлэх  
тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29.2 дугаар заалт, Засгийн газрын 2013 оны 370 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нийгмийн түншлэлийг хөгжүүлэх тухай Засгийн газрын 2013 оны 370 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор дараах арга хэмжээнүүдийг тусгасан төлөвлөгөө гарган ажиллахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай. Үүнд:

1.1 Сумын Засаг даргын зөвлөлийн бүрэлдэхүүнд Үйлдвэрчний эвлэлийн холбооны болон Ажил олгогч эздийн холбооны төлөөллийг оруулж ажиллах,

1.2. Хөдөлмөр нийгмийн зөвшлийн 3 талт улсын болон аймгийн хэлэлцээртэй уялдуулан сумын хамтын гэрээг байгуулж хэрэгжүүлэх,

1.3. Хөдөлмөрийн болон Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах, хөдөлмөрийн маргаан шуурхай зохицуулах үүрэг бүхий талуудын төлөөлөл оролцсон сумын салбар хороог байгуулан хуулийн хэрэгжилтэнд хяналт тавьж, зөрчил дутагдлыг арилгуулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх,

1.4. Инфляцийн түвшин, салбарын онцлог, хөдөлмөрийн бүтээмжтэй уялдуулан цалин хэлс, тэтгэвэр нэмэгдүүлэх талаар ажил олгогч, Үйлдвэрчний эвлэлийн холбооны төлөөллийн саналыг тусгаж холбогдох дээд шатны байгууллагад уламжилж, эгэх буцах холбоо үүсгэн ажиллах,

2. Захирамжийн хэрэгжилтийг жил бүрийн 06 дугаар сарын 15, 12 дугаар сарын 25-нд аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэст ирүүлж байхыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.


3. Сумдын Засаг дарга, түүний Тамгын газрын жилийн үйл ажиллагааг дүгнэхдээ Засгийн газрын 2013 оны 370 дугаар тогтоолын болон энэхүү захирамжийн хэрэгжилтийг үзүүлэлт болгон оруулж, дүгнэж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн дарга /Ч.Уртнасан/-д, захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг

Zahiramj-2018-A/53

• 0 1 1 0 1 0 4

даргын тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга /Ж.Ганболд/-д тус тус даалгасугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2014 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн А/49 тоот захирамжийг хүчингүйд тооцсугай.





МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2018 оны 01 сарын 24 өдөр

Дугаар A/54

Мөрөн

Ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.1 дэх заалт, Гамшигаас хамгаалах тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1, 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.12 дахь заалт, Авто тээврийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь заалт, 21 дүгээр зүйлийн 21.1.1 дэхь заалт, Зөрчлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.15, 14 дүгээр зүйлийн 14.6, 14.21.3, 14 дүгээр зүйлийн 14.7 дугаар заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь.:

1. 2018 оны 1 дүгээр сарын 21-ний өдрийн 01 цагийн үед Мөрөн сумсаас дүгээр зүйлийн Ханх сумын чиглэлд зорчиж явсан Ханх сумын ЕБС-ийн 03-52 ХӨА улсын дугаартай фургон автомашин Ханх сумын Тураг 1 дүгээр баг “Модон хүй арал” гэдэг газар /сумын төвөөс баруун урд зүгт 70 км-т/ Хөвсгөл нууранд мөс цөмөрч /хар хил рүү/ нуурын ус руу орсон ослын улмаас үүссэн хохирлыг хянах, судлах, барагдуулах, цаашид авах арга хэмжээг төлөвлөх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Онцгой байдлын газар-Гамшигаас хамгаалах улсын хяналтын ахлах байцаагч, хошууч Л.Бямбасүрэн

Хэсгийн бүрэлдэхүүнд: Мэргэжлийн хяналтын газар – Авто тээврийн хяналтын улсын байцаагч Б.Сэргэлэн

Цагдаагийн газар – Замын цагдаагийн тасгийн дарга, дэд хурандаа Ц.Нямбат

Хөвсгөл нуур, Эгийн голын сав газрын захиргааны дарга Б.Ундармаа  
Улсын тусгай хамгаалалттай газрын захиргаа – Хяналт шалгалт хариуцсан мэргэжилтэн Г.Цогтбаяр

Байгаль орчин, аялал жуулчлалын газар – Усны нөөц хариуцсан мэргэжилтэн Х.Пүрэвдорж

Зам тээврийн яамны далайн захиргаа – Тээвэр усан замын хяналтын улсын байцаагч Б.Нэргүй


Авто тээврийн газар – Авто тээврийн хяналтын улсын байцаагч М.Амарбаясгалан

Боловсрол, соёл урлагийн газар - Төсвийн мэргэжилтэн Б.Далайжаргал

2. Ослын шалтгаан нөхцлийг судлан, ослын улмаас үүссэн эд хөрөнгийн болон байгаль экологийн хохирлын үнэлгээ хийх, хохирлыг арилгах боломж, цаашид авах арга хэмжээний санал боловсруулж аймгийн Онцгой комисст танилцуулахыг ажлын хэсгийн бүрэлдэхүүнд үүрэг болгосугай.

3. Ажлын хэсгийн үйл ажиллагааны зардал 504400 төгрөгийг аймгийн Засаг даргын нөөцөөс тооцон олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Х.Ган-Очир/-д зөвшөөрсүгэй.

4. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч А.Эрдэнэбаатарт даалгасугай.





МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2018 оны 01 сарын 24 өдөр

Дугаар A/55

Мөрөн

Усны гарвалтай ослоос урьдчилан  
сэргийлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ын "б", 30 дугаар зүйлийн 30.1.6, Гамшиг хамгаалах тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1, 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8, дахь заалт, Авто тээврийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.6 дахь заалт, Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалтын 2.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь.

1. 2017-2018 оны өвлийн цаг уурын байдлаас шалтгаалан гол мөрөн нуур цөөрөм бүрэн гүйцэд хөлдөөгүй, бүрэн хөлдсөн хэсэгтэй ч хар, цагаан хил байнга гарч байгагаас иргэд, зорчигч тээврийн хэрэгсэл зам товчлооор мөсөн замаар зорчин явж амь нас, эрүүл мэнд, тээврийн хэрэгслээ эрсдэлд оруулж болзошгүй нөхцөл байдал үүсч байгаа тул 2018 оны 01 дүгээр сарын 22-ноос эхлэн 2018 оны 2 дугаар сарын 25 хүртэл Хөвсгөл нуурын болон бусад гол мөрний мөсөөр зорчих явдлыг таслан зогсоосугай.

2. Усны гарвалтай осол эндэгдэл гарахаас урьдчилан сэргийлэх зорилгоор холбогдох мэргэжлийн байгууллагуудаас албан хаагчдыг оролцуулсан ажлын хэсгийг 1 дүгээр хавсралтаар батлан, Хөвсгөл нуурын орчимд 2018 оны 01 дүгээр сарын 20-ноос 2018 оны 02 дугаар сарын 25-ыг хүртэл хяналтын цэгийн хэлбэрээр ажиллуулсугай.

3. Ажлын хэсгийн томилолтын болон зарцуулагдах шатах тослох материалын тооцоог 2 дугаар хавсралтаар баталж шаардагдах 6912000 төгрөгийн зардлыг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргаж зарцуулахыг аймгийн ЗДТГ-ын дарга /Х.Ган-Очир/-д зөвшөөрсүгэй.

4. Ажлын хэсгийн ажиллах удирдамжийг боловсруулж, хяналтын хэсэг бүрт ажиллах хуваарийг гарган мэргэжлийн удирдлагаар хангаж сум орон нутагт усны гарвалтай ослоос урьдчилан сэргийлэх ажил зохион байгуулж, Онцгой байдлын газарт мэдээ мэдээллийг ирүүлж ажиллахыг сумдын Засаг дарга нарт даалгасугай.

5. Энэхүү захирамжийн биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын гарын дарга /Х.Ган-Очир/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Л.ГАНБОЛД



Zahiramj-2018-A/55  
110155



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2018 оны 01 сарын 26 өдөр


Дугаар A/56

Мөрөн

Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 30 дугаар зүйлийн 30.1.6, Цагдаагийн албаны тухай хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1, Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалтын 2.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нийтийн хэв журам хамгаалах чиг үүргийг хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлж, албан хаагчдын нийгмийн баталгааг сайжруулах зорилгоор аймгийн Цагдаагийн газрын Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх мэргэжилтэн, ахлах дэслэгч Ю.Одгэрэл, Мэдээлэл хүлээн авагч цагдаа, ахлагч Г.Уранцэцэг, үйлчлэгч Ш.Цэцэгсайхан, Б.Цэрэндэжид нарт тус бүр 500,000 /таван зуун мянга/ төгрөгөөр дэмжлэг үзүүлсүгэй.
2. Дэмжлэгт зарцуулагдах нийт 2000,000 /хоёр сая/ төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг аймгийн ЗДТГ-ын дарга (Х.Ган-Очир)-д зөвшөөрсүгэй.
3. Захирамжийн биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн ЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга /Г.Гандэлгэр/-д даалгасугай.





МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2018 оны 01 сарын 26 өдөр

Дугаар A/57

Мөрөн

Дэмжлэг үзүүлэх тухай


Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 30 дугаар зүйлийн 30.1.6, Цагдаагийн албаны тухай хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1, Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалтын 2.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Хариуцлага хамтын үйл ажиллагааг дээшлүүлэх" жилийн ажлын хүрээнд нийтийн хэв журам хамгаалах, гамшигаас хамгаалах, батлан хамгаалах, улсын хил хамгаалах чиг үүргийг 2017 онд хамт олноо манлайлан, үр дүнтэй хэрэгжүүлсэн дараах нэр бүхий албан хаагчдад тус бүр 500,000 /таван зуун мянга/ төгрөгөөр дэмжлэг үзүүлсүгэй. Үүнд:

- Т.Бүрэнхаан –Аймаг дахь Шүүхийн шинжилгээний албаны ахлах шинжээч, ахмад
- Д.Уртбаяр – Аймаг дахь Цагдаагийн газрын Захиргааны удирдлагын тасгийн дарга, дэд хурандаа
- А.Мөнхөө – Аймгийн Онцгой байдлын газрын Техник хэрэгсэл хөдөлмөр хамгаалал хариуцсан мэргэжилтэн, дэслэгч
- Б.Амартувшин- Хилийн 0257 дугаар ангийн Санхүүгийн албаны дарга, ахмад
- П.Буяндэлгэр – Зэвсэгт хүчний 321 дүгээр тусгай салбарын Зэвсгийн нярав, ахлах ахлагч
- Ш.Гансүх – Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын дэд дарга, дэд хурандаа

2. Дэмжлэгт зарцуулагдах нийт 3000,000 (гурван сая) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг аймгийн ЗДТГ-ын дарга (Х.Ган-Очир)-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн ЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга /Г.Гандэлгэр/-д даалгасугай.





МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2018 оны 01 сарын 26 өдөр

Дугаар A/58

Мөрөн

Шагнал урамшуулал олгох тухай


Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2, Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалын 2.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн ажилд өндөр үр бүтээл гарган 2017 оны аймгийн шилдэг санхүүчээр шалгарсан тул

- Ц.Мөнхтуяа-Аймгийн ЗДТГ-ын СТСХ-т Ерөнхий нягтлан бодогч
- Ц.Бэхбаяр- Орон нутгийн өмчийн газарт өмч хариуцсан мэргэжилтэн
- Н.Далайжаргал-БСҮГ-ын төсөв, хөрөнгө оруулалт хариуцсан ахлах мэргэжилтэн
- Б.Батчимэг-ЭМГ-ын ЭМУ-ын хэлтсийн дарга
- Х.Болд-Эрдэнэ-“Ус-Суваг” ХХК-ний ерөнхий нягтлан бодогч нарыг тус бүр 1000,000 /нэг сая төгрөг/ төгрөгөөр шагнаж урамшуулсугай.

2. Шагналд зарцуулагдах нийт 5000,000 /таван сая/ төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц сангаас гаргахыг аймгийн ЗДТГ-ын нягтлан бодогч /Ц.Нармандах/-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Г.Сувд/-д даалгасугай.



Zahirami-2018-A/58  
Олон улсын  
ЗАХИРАМЖ



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2018 оны 01 сарын 26 өдөр

Дугаар A/59

Мөрөн


Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29.1.6-ийн “г” заалт, Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалтын 2.1.3. дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлын 2018 оны 03 дугаар шийдвэрээр Мөрөн сумын иргэн Р.Отгонцэцэг, Б.Хүрэлчулун, Д.Цэрэнчимэг, Н.Оюунцэцэг, Б.Угантуяа, Г.Лхагважав, Д.Жавзандулам, Л.Чимгээ, Д.Үнэнбат, Шинэ-Идэр сумын иргэн Я.Даваасүрэн нарт тус бүрт нь 50000 төгрөгний дэмжлэг, Цэцэрлэг сумын иргэн Ж.Эзвэнжав, Б.Батбаатар нарт тус бүрт нь 100000 төгрөг, Мөрөн сумын иргэн Э.Мөнхбатад 600000 төгрөг, Улаан-Уул сумын иргэн С.Оюумаад 100000 төгрөг, Чандмань-Өндөр сумын иргэн Ц.Сэргжавт 200000 төгрөг, дээрх иргэдэд эмчилгээний зардал, амьдралын аргагүй байдлыг харгалзан үзэж дэмжлэг үзүүлсүгэй.

2. Дээрх 1550000 /Нэг сая таван зуун тавин мянга/ төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Х.Ган-Очир/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Л. ГАНБОЛД